

НАМ, ЭВСЭЛ СОНГУУЛЬД ОРОЛЦОХОО ИЛЭРХИЙЛЖ, БҮРТГҮҮЛЭХ

2020.5.01-нээс өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн,
тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэгт өөрийн салбартай нам сонгуульд оролцох эрхтэй.
Эвсэлд нэгдсэн нам тус бүр дээрх шаардлагыг хангасан байна.

Нам, эвсэл нь Монгол Улсын Үндсэн хууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг дагаж мөрдөхөө илэрхийлэн, сонгуульд оролцох тухай хүсэлтээ **2020.8.16-наас өмнө** тухайн шатны сонгуулийн хороонд ирүүлнэ.
/АНСДИТХ-ын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйл/

НАМ

1. Сонгуульд оролцох тухай тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх намын байгууллагын шийдвэр, намын даргыг томилсон шийдвэр;
2. Намын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
3. Намын улсын бүртгэлд бүртгүүлсэн дүрмийн хуулбар;
4. Сонгуулийн мөрийн хөтөлбөр;
5. Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн эдийн засгийн тооцоонд хийсэн төрийн аудитын байгууллагын дүгнэлт;
6. Хуульд нийцсэн нэр дэвшүүлэх ажиллагааны талаарх намын дотоод журам;
7. **2019.01.01-нээс 2020.6.01-ний өдрийг хүртэлх** хугацаанд тухайн намд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын төрийн аудитын байгууллагаар хянуулж баталгаажуулсан тайлан;
8. Намын сонгууль эрхэлсэн байгууллагын бүтэц, бүрэлдэхүүн, хаяг, харилцах утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажиллах хүний тоо зэргийг агуулсан мэдээлэл;
9. Намыг төлөөлж тухайн шатны сонгуулийн хороотой харилцах 3 хүний эцэг /эх/-ийн болон өөрийн нь нэр, хүн тус бүрийн харилцах утасны дугаар, цахим шуудангийн хаяг.

ЭВСЭЛ

1. Сонгуульд оролцох тухай эвслийг төлөөлөх байгууллагын шийдвэр;
2. Эвсэлд нэгдсэн нам тус бүрийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
3. Эвсэлд нэгдсэн нам тус бүрийн улсын бүртгэлд бүртгүүлсэн дүрмийн хуулбар;
4. Эвслийг төлөөлөх байгууллагаар батлагдсан сонгуулийн мөрийн хөтөлбөр;
5. Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн эдийн засгийн тооцоонд хийсэн төрийн аудитын байгууллагын дүгнэлт;
6. Хуульд нийцсэн нэр дэвшүүлэх ажиллагааны талаарх эвслийн дотоод журам;
7. **2019.01.01-нээс 2020.6.01-ний өдрийг хүртэлх** хугацаанд нам тус бүрд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын төрийн аудитын байгууллагаар хянуулж баталгаажуулсан тайлан;
8. Эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын бүтэц, бүрэлдэхүүн, хаяг, харилцах утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажиллах хүний тоо зэргийг агуулсан мэдээлэл;
9. Эвслийг төлөөлж тухайн шатны сонгуулийн хороотой харилцах 3 хүний эцэг /эх/-ийн болон өөрийн нь нэр, хүн тус бүрийн харилцах утасны дугаар, цахим шуудангийн хаяг;
10. Эвслийн гэрээний хуулбар;
11. Эвсэл байгуулах тухай нам тус бүрийн шийдвэр.

ТУХАЙН ШАТНЫ СОНГУУЛИЙН ХОРОО

Нам, эвслээс ирүүлсэн баримт бичгийг нягтлан шалгаад, хүлээн авснаас хойш **5 хоногт багтаан** сонгуульд оролцох нам, эвслийг бүртгэх эсэх тухай шийдвэр гаргана.
2020 оны 8 дугаар сарын 20-ны өдөрт багтаан